**ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН**
**ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН**
# ТУШААЛ

2022 оны 11 сарын 15 өдөр Дугаар А/77 Улаанбаатар хот

Баримт бичигт дүн шинжилгээ хийх тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 дэх заалт, MNS ISO/TR 10013:2001, MNS ISO 9001:2016 стандартын шалгуур, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/136 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цус сэлбэлт судлалын үндэсний төвд мөрдөгдөж буй 2 дугаар түвшний баримт бичигт дүн шинжилгээ хийх ажлын удирдамжийг 1 дүгээр, төлөвлөгөө 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дүн шинжилгээг 2022 оны 11-р сарын 18-ны дотор дуусгаж танилцуулахыг Цусны чанар, аюулгүй байдлын албаны дарга /А.Амарзаяа/-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, маркетингийн албаны дарга /Ч.Батболд/-д даалгасугай

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Н.ЭРДЭНЭБАЯР

1118266548 9128905

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2022 оны ... сарын ....-ны
өдрийн ...... дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

1118266548 9128905

БАРИМТ БИЧИГТ ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ

**Нэг. Зорилго:**

1.1. Төвийн Чанарын менежментийн тогтолцоо болон Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын тогтолцоонд мөрдөгдөж буй үйл ажиллагаатай холбоотой журам боловсруулахад тулгамдаж буй асуудал, боловсруулсан журмуудын хэрэгжилт, стандартын нийцлийг үнэлэхэд энэхүү ажлын гол зорилго оршино.

**Хоёр. Зорилт:**

3.1. ЦССҮТ-д мөрдөгдөж байгаа нийт журмуудын хэрэгжилт, стандартын нийцэлд үнэлгээ хийх

3.2. Журам боловсруулахад тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, журам боловсруулах аргачлалыг тодорхойлох

**Гурав. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

3.1. Төвийн Чанар болон ХЭМАБ-ын менежментийн тогтолцоонд хамаарах баримт бичигт дүн шинжилгээ хийх шалгуур үзүүлэлт боловсруулж, мэргэжил арга зүйгээр хангана.

3.2. Төлөвлөгөөний дагуу дүн шинжилгээ хийж, Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

3.3. Алба, тасгийн эрхлэгч нарт журам боловсруулах аргачлалын сургалт зохион байгуулна.

**Дөрөв. Хугацаа**

5.2. 2022 оны 11 дугаар сарын 15-ны өдрөөс 2022 оны 11 дугаар сарын 18-ны өдрийн хооронд үргэлжилнэ.

**Тав. Хамрах хүрээ**

5.1. Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн холбогдох алба, тасаг, багууд

**Зургаа.Хариуцах эзэн**

6.1. Ажлын хэсэг болон дэд ажлын хэсгүүдийн ахлагч нар

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2022 оны ... сарын ....-ны
өдрийн ...., дугаар тушаалын
2 дугаар хавсралт

# БАРИМТ БИЧИГТ ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Ажлын хэсгийн дугаар | Ажлын хэсгийн ахлагч | Ажлын хэсгийн гишүүд | Журмын нэр |
|---|---|---|---|---|
| 1. | Ажлын хэсэг | Дотоод аудитор Э.Тунгалагтуяа | Алба, тасгийн дарга, эрхлэгч нар | 1. Дотоод журам<br>2. Удирдлагын зөвлөлийн ажиллах журам<br>3. Удирдлагын дүн шинжилгээ хийх журам<br>4. Дотоод аудит зохион байгуулах журам<br>5. Гамшгийн бэлэн байдал хангах, гамшгийн үед үйл ажиллагаа явуулах журам<br>6. Мөнгөн урамшуулал олгох журам<br>7. Өргөдөл, гомдол хүлээн авах, шийдвэрлэх, хяналт тавих журам |
| 2. | Дэд ажлын хэсэг 1 | ЗМА-ны дарга Ч.Батболд | Хүний нөөц, хуулийн зөвлөх Я.Тогтохням<br>Нийгмийн ажилтан Д.Дулмаа<br>Маркетингийн ажилтан Р.Энхтуяа | 1. Ажилтан сонгон шалгаруулах, дадлагажуулан сургах, туршилтаар ажиллуулах, үндсэн ажилтнаар томилох журам<br>2. Маркетингийн үйл ажиллагааны журам<br>3. Автомашин болон зогсоол ашиглалтын журам<br>4. Цусны донорыг алдаршуулах, урамшуулах журам<br>5. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам<br>6. Явуулын хэлбэрээр цус цуглуулах үйл ажиллагааны журам |
| 3. | Дэд ажлын хэсэг 2 | ЦЧАБА-ны дарга А.Амарзаяа | Чанарын менежмент, эрсдлийн | 1. Баримт бичиг боловсруулах, дугаарлах, кодлох, архивлах журам |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | удирдлагын баг | 2. Баримт бичиг хянах журам<br>3. Үйл явцын тодорхойлолт боловсруулах журам<br>4. Халдварын сэргийлэлт хяналтын журам<br>5. Цусны сонор сэрэмжийн тогтолцоог хэрэгжүүлэх журам<br>6. Тусламж үйлчилгээтэй холбоотой үүссэн тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах журам<br>7. Алдаа зөрчил, үл тохирлын багийн ажиллах журам<br>8. Ижил мэргэжилтний үнэлгээний журам<br>9. Сонирхогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа авах, судалгааны мөрөөр ирүүлсэн саналыг хүлээн авах, бүртгэх журам<br>10. Үндсэн үйл ажиллагааны мэдээ тайлан ирүүлэх журам<br>11. Цусны салбар төвүүдийн жилийн үйл ажиллагааг дүгнэх журам |
| 4. | Дэд ажлын хэсэг 3 | СБА-ны дарга Х.Одгэрэл | Тооцооны нягтлан бодогч Б.Алтанзул<br>Нярав Б.Буриад | 1. Бараа материал худалдан авах журам<br>2. Мөнгөн кассын ажиллах журам<br>3. Тооллого явуулахад баримтлах журам<br>4. Төлбөр тооцоог гүйцэтгэх журам<br>5. Ахлах сувилагч, эд хариуцагчийн ажиллах журам<br>6. Албан томилолтоор ажиллах журам |
| 5. | Дэд ажлын хэсэг 4 | ИТТ-ийн эрхлэгч Б.Додьгалсан | ЗМА-ны дарга Ч.Батболд<br>Инженер М.Дааваням | 1. Эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн бүртгэл, засвар үйлчилгээ хийх журам<br>2. Хэмжүүр, хэмжих, хянах хэрэгслүүдийг баталгаажуулах, түүний ашиглалтанд хяналт тавих журам |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6. | Дэд ажлын хэсэг 5 | ДЗБТ-ийн эрхлэгч Ч.Тунгалаг | Их эмч Ё.Улсболд Д.Наранхүү Б.Ижилбаатар | 1. Цусны донорын сонор сэрэмжийн тогтолцоог хэрэгжүүлэх журам<br>2. Донор, үйлчлүүлэгчид зөвлөгөө өгөх журам<br>3. Үйлчлүүлэгчийн өмчийг хамгаалах журам |
| 7. | Дэд ажлын хэсэг 6 | ҮТ-ийн эрхлэгч Н.Халиун | Их эмч Б.Оргил | 1. SARS Cov-2 эсрэг бие агуулсан сийвэн цуглуулах, шинжлэх, үйлдвэрлэх, хадгалах, түр олгох заавар<br>2. Үйлчлүүлэгчийн өмчийг хамгаалах журам |
| 8. | Дэд ажлын хэсэг 7 | ЭШМТА-ны дарга Б.Солонго | Инженер Ч.Далайцэрэн Х.Гунгаанаран Сургалт төслийн ажилтан Б.Энхболор | 1. Эрдэм шинжилгээний журнал клубын үйл ажиллагааны журам<br>2. ЦССҮТ-ийн нууцлалын журам<br>3. Үндсэн үйл ажиллагааны цахим мэдээлэлд засвар өөрчлөлт хийх журам<br>4. Төвийн цахим хуудас аппликэйшний үйл ажиллагааны журам<br>5. Цусны албаны мэдээллийн аюулгүй байдлын журам<br>6. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх журам |
| 9. | Дэд ажлын хэсэг 8 | - | Ёс зүйн баг | 1. Төвийн эмч, ажиллагсдын ёс зүйн журам |
| 10. | Дэд ажлын хэсэг 9 | - | ХЭМАБ-ын баг | 1. Химийн бодистой ажиллах журам<br>2. ХЭМАБ-ын зөвлөлийн ажиллах журам<br>3. ХЭМАБ-ын сургалт зохион байгуулах, зааварчилгаа өгөх журам<br>4. ХЭМАБ-ын үүрэг хариуцлагын журам<br>5. ХЭМАБ-ын харилцаа холбооны журам<br>6. ХЭМАБ-ын гүйцэтгэлийн үнэлэмжийн журам<br>7. Хууль тогтоомжийн шаардлагыг тогтоох, хэрэглэх, үнэлэх журам |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | 8. Аюулыг тогтоох эрсдлийг судлан бүртгэх, үнэлэх, бууруулах ажиллагааны журам<br>9. Аюултай тохиолдлыг судлан бүртгэх журам |
| 11. | Дэд ажлын хэсэг 10 | - | Байгууллагын соёл, хамтач ажиллагааны баг | 1. Ажлын байран дахь хувцаслалтын журам<br>2. Байгууллагын соёл, үйлчилгээнд мөрдөх журам |